



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/172

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 5/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Амарсанаагийн 3 дугаар гудамжны 302 б тоотод байрлах, 61 метр квадрат газрыг өвлөх эрхийн гэрчилгээний дагуу Лувсаны Бүрэнбаясахад /ПМ72092000/ гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Жаргалант хайрхан 2 дугаар гудамжны 207 тоотод байрлах 353 метр квадрат газрыг Дагванамжилын Чойжоод /ПП73012414/ гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/172 Ch
02 00796